

Танилцуулгыг хянан тохиосон:

Х.Өлзийсүрэн Статистикийн хэлтсийн дарга

Танилцуулгыг нэгтгэн боловсруулсан:

Б.Цэрэндорж Статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
А.Амарзаяа Статистикийн хэлтсийн мэргэжилтэн
Б.Энхцэцэг Статистикийн хэлтсийн мэргэжилтэн

ДОРНОГОВЬ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

Дорноговь аймаг, Сайншанд хот

Гуравдугаар баг, гудамж-00

АЗДТГ-ын байр

Утас: 70522749

Цахим шуудан: dornogovi.nso.mn

И-мэйл хаяг: dornogovi@nso.mn

АГУУЛГА

ОРШИЛ

НЭГ. ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

ХОЁР. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР

ГУРАВ. БАРИЛГЫН САЛБАР

ДӨРӨВ. ЭДИЙН ЗАСАГТ ХУДАЛДААНЫ САЛБАРЫН ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

ХҮСНЭГТ2.1 БҮРТГЭЛТЭЙ АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН ТОО, салбараар

ХҮСНЭГТ2.2 БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, гол нэр төрлөөр, биет хэмжээгээр

ХҮСНЭГТ2.3 АЖ ҮЙЛДВЭРИЙН МЭДЭЭНД ХАМРАГДСАН АЖ АХУЙН НЭГЖ, ИРГЭДИЙН ТОО

ХҮСНЭГТ2.4 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН АЖИЛЛАГЧДЫН ТОО

ХҮСНЭГТ2.5 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ХӨДӨЛМӨРИЙН БҮТЭЭМЖ, салбар, дэд салбараар, мян төг

ХҮСНЭГТ3.1 БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, оны үнээр, сая төгрөг

ХҮСНЭГТ3.2 АШИГЛАЛТАНД ОРУУЛСАН ОРОН СУУЦ, м2, оны эцэст

ХҮСНЭГТ4.1 ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО 2016-2019 оноор

ХҮСНЭГТ4.2 ХУДАЛДААНЫ НИЙТ БОРЛУУЛАЛТ аймаг, бүсээр сая төгрөг 2016-2019 он

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

ЗУРАГ2.1 ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН ТОО, дэд салбараар

ЗУРАГ2.2 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН ТОО, дэд салбар, хувиар

ЗУРАГ2.3 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛТ, дэд салбараар, тэрбум төгрөгөөр

ЗУРАГ2.4 НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ, тэрбум төгрөгөөр, 2010-2019 он

ЗУРАГ2.5 НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ, тэрбум төгрөгөөр, 2010-2019 он

ЗУРАГ2.6 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ, аж ахуй нэгжийн хэлбэрээр, хувиар

ЗУРАГ2.7 АЖ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРЫН 2019 ОНЫ НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛТ, сумаар, сая төгрөг

ЗУРАГ2.8 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН 2019 ОНЫ НИЙТ БОРЛУУЛАЛТ, дэд салбараар

ЗУРАГ2.9 НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БОРЛУУЛАЛТ, тэрбум төгрөгөөр, 2010-2019 он

ЗУРАГ3.1 БАРИЛГЫН САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ААНБ-ЫН ТОО, жил бүрийн эцэст

ЗУРАГ3.2 БАРИЛГЫН САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТӨГ, үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр, сая төгрөгөөр

ЗУРАГ3.3 БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, төрлөөр, мян төг

ЗУРАГ3.4 АШИГЛАЛТАНД ОРУУЛСАН ОРОН СУУЦАНД АМЬДАРЧ БУЙ өрх, хүн амын тоо

ЗУРАГ4.1 ХУДАЛДААНЫ САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ, ажиллагчдын тооны бүлгээр

ЗУРАГ4.2 ХУДАЛДААНЫ САЛБАРТ АЖИЛЛАГЧДЫН ТОО

ОРШИЛ

Манай аймаг нь аймаг ашигт малтмалаар баялаг бөгөөд одоогийн байдлаар хайлуур жонш, цеолет, гөлтгөнө, чулуун нүүрс, газрын тос, алт, зэс, никель, төмөр, марганец, хром, гянт болд, цагаан тугалганы зэрэг 38 төрлийн ашигт малтмалын 73 орд, 440 гаруй илэрцүүд тогтоогдсон байна. Мөн тус аймагт Монгол орны хэмжээнд тогтоогдсон хайлуур жоншны нийт нөөцийн 30.0 хувь бий.

Байгалийн баялаг, ашигт малтмал, эрдсийн энэхүү ихээхэн нөөц нь уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэрлэл хөгжих тааламжтай нөхцөл болж байна. Тус аймгийн нутагт орон нутгийн төдийгүй, улс орны эдийн засгийн онцгой ач холбогдол бүхий Зүүнбаян, Цагаан элсний газрын тос агуулсан хотгор байрладаг. Даланжаргалан сумын Хөх цав болон Өргөн сумын Сэнжит худгийн ордуудыг түшиглэн жилд 1 сая тн-н хүчин чадалтай цементүүдийн үйлдвэрүүд ашиглалтад ороод байна.

Эдгээр үйлдвэрүүдэд эрчим хүч, зам харилцаа, усан хангамж, нийгмийн дэд бүтцүүдийг бий болгож хөгжүүлэх явдал тус аймгийн хувьд геологи, уул уурхайн салбарт дэвшүүлэн тавьж байгаа томоохон зорилтууд болно.

Дорноговь аймгийн бүх сумд цахилгаан эрчим хүчний нэгдсэн сүлжээнд бүрэн холбогдсон бөгөөд үйл ажиллагааг БЗӨБЦТС ТӨХК-ийн Чойр, Дорноговь салбар, УБТЗ ХНН-ийн ЭХУХ 2-р анги тус тус хариуцан ажиллаж байна. Айраг, Иххэт, Өргөн, Эрдэнэ, Замын-Үүд, Сайншанд сумд болон Зүүнбаян баг нь төвлөрсөн ус, дулаан хангамжийн шугам сүлжээнд холбогдсон бөгөөд тус сумдын ус, дулаан хангамж, нийтийн аж ахуйн салбарын үйл ажиллагааг “Чандмань-Илч”ХХК, “Чандмань Бадрал” ХХК, “Сизу” ХХК, УБТЗ ХНН-ийн ЭХУХ 2-р анги, БАҮ-ний 3-р ангиуд тус тус хариуцан ажиллаж байна.

Дорноговь аймгийн авто замын сүлжээний нийт урт 3000 гаруй км авто замтай бөгөөд үүнээс Чойр-Сайншанд-Замын-Үүд чиглэлийн босоо тэнхлэгийн улсын чанартай 434,1 км хатуу хучилттай авто зам эзэлдэг.

Тус аймагт Зүүнбаян-Тавантолгой чиглэлийн 414.6 км төмөр замын бүтээн байгуулалтын ажил хийгдэж, одоогийн байдлаар, 50 км суурь далан шорооны ажил хийгдэж 1.9 километр төмөр зам баригдаад байна.

Мөн Алтанширээ сумын нутаг дэвсгэрийн 150 га талбайд газрын тос боловсруулах үйлдвэр баригдаж эхэлж байгаа бөгөөд одоогоор Сайншандаас Газрын тос боловсруулах үйлдвэрийн талбай хүртэлх 110/10 кВ-ын 18,2 км ЦДАШ, дэд станц, 18,8 км төмөр зам, 16,8 км авто зам барих чиглэлийг баталж ашиглалтад оруулсан. Батлан хамгаалах яамны захиалгаар Газрын тос боловсруулах үйлдвэрийн ажилчдын 549 айлын орон сууцны 1-р ээлжийн 262 айлын орон сууцны барилгын ажлын гүйцэтгэл 20%-тай байна.

Сайншанд сумын нутаг дэвсгэр 486 га газарт 55 МВт хүчин чадал бүхий салхин цахилгаан станц, Замын-Үүд суманд 15 МВт хүчин чадал бүхий нарны цахилгаан станцтай. Уг нар, салхины станц нь Дорноговь аймгийн нийт эрчим хүчний хэрэглээний 80% -тай дүйцэхүйц хэмжээний эрчим хүч үйлдвэрлэж 1 сард дунджаар 10сая кВ/цаг эрчим хүчийг үйлдвэрлэн төвийн эрчим хүчний системд нийлүүлж байна.

НЭГ. ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Аж үйлдвэрийн салбар

Ойлголт	Тодорхойлолт
Нийт үйлдвэрлэл	Тайлант хугацаанд шинээр үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүний нийт дүн (тухайн оны үнээр)-г хэлнэ
Завсрын хэрэглээ	Үйлдвэрлэл, үйлчилгээний явцад орц болж зарцуулагдсан бүтээгдэхүүний зардал (худалдан авсан барааны өртгөөс жилийн эцсийн нөөцийн өөрчлөлтийг хасна) болон үйлчилгээний төлбөрийг хэлнэ.
Нэмэгдэл өртөг	Нийт үйлдвэрлэлээс завсрын хэрэглээг хассан дүнг хэлнэ. Нийт үйлдвэрлэлийн нүндсэн үнээр, завсрын хэрэглээг худалдан авагчийн үнээр үнэлнэ.
Бүтээгдэхүүний борлуулалт	Тайлант хугацаанд худалдсан буюу бусдад зориулж гүйцэтгэсэн ажил үйлчилгээг хэлнэ. Нийт борлуулалтад тухайн үйлдвэрлэлийн болон үйлдвэрлэлийн бус бүтээгдэхүүн ажил үйлчилгээний борлуулалтад орно. Хэрэв захиалагч бүтээгдэхүүнийхээ төлбөрийг урьдчилан төлсөн бол уг бүтээгдэхүүнийг борлуулагдсан гэж үзнэ.
Аж үйлдвэрийн борлуулалт	Зөвхөн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалтыг хамруулна. Энд үйлдвэрлэлийн бус бүтээгдэхүүн, үйлчилгээ, үндсэн хөрөнгө, түүхий эд материал зэргийн худалдан борлуулсан хэмжээг хамруулахгүй.
Үндсэн үнэ	Аливаа бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэлд гарсан зардал, ашгаа тооцон багтаасан үнийг үндсэн үнэ гэнэ. Үндсэн үнэд татварыг оруулж тооцохгүй ба татаасыг оруулж тооцно.
Үйлдвэрлэгчийн үнэ	Үндсэн үнэ дээр бүтээгдэхүүний борлуулалтад ногдуулдаг бараа, үйлчилгээний татвар (нэмэгдсэн өртгийн татвараас бусад) болон тээвэр, худалдааны нэмэгдлүүдийг нэмж, татаасыг хасаж тооцсон үнийг хэлнэ.
Зах зээлийн үнэ буюу худалдан авагчийн үнэ	Үйлдвэрлэгчийн үнэ дээр бүтээгдэхүүний борлуулалтад ногдуулдаг нэмэгдэл өртгийн албан татварыг нэмж тооцсон үнийг хэлнэ.
Бүтээгдэхүүн	Үйлдвэрлэлийн үр дүнд бий болсон бараа, үйлчилгээг хэлнэ.
Хагас боловсруулсан бүтээгдэхүүн (дуусаагүй үйлдвэрлэл)	Зах зээлд нийлүүлэхэд үйлдвэрлэл нь хараахан дуусаагүй бэлэн бус бүтээгдэхүүнийг хэлнэ.
Гол нэр төрлийн бүтээгдэхүүн	Тайлант хугацаанд үйлдвэрлэсэн салбарын үйлдвэрлэлийг төлөөлөхүйц бүтээгдэхүүнийг хэлнэ.
Ажиллагч	Цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож, хөдөлмөр эрхлэлтийн статуст

	хамрагдаж буй иргэнийг хэлнэ. Ажил эрхлэлттэй холбоотой ойлголт, тодорхойлолт нь хөдөлмөрийн статистикт ашигладаг ойлголт, тодорхойлолттой адил байна.
Ажилласан цаг	Тайлант хугацаанд ажиллагчид (цалин хөлстэй ажиллагч болон цалин хөлсгүй ажиллагч)-ийн ажилласан цагийг хэлнэ.

ХАМРАХ ХҮРЭЭ

Аж үйлдвэрийн салбарын богино хугацааны (сарын) мэдээгэдийн засгийн бүх төрлийн үйлчиллэгийн салбарын ангилал (ISIC-3.1)-т, урт хугацааны (жилийн) мэдээг эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал (ISIC-4.0)-ындагуу уул уурхай, олборлох үйлдвэр, боловсруулах үйлдвэрлэл, цахилгаан, хий, уур, агааржуулалт, усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа гэсэн 4 дэд салбарыг хамруулан авч үздэг.

Салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээг тооцохдоо үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээг үндсэн буюу үйлдвэрлэгчийн үнээр тооцдог бөгөөд бэлэн бүтээгдэхүүн, дуусаагүй үйлдвэрлэлийн өөрчлөлтийг мөн үнэлж тусгадаг.

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээг тооцох мэдээллийн эх үүсвэр нь бизнес регистрийн санд бүртгэлтэй аж үйлдвэрийн салбарт үйлчиллэгийн явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны тайлан болон холбогдох захиргааны статистик мэдээлэл болно. Мэдээллийг сарын болон жилийн давтамжтайгаар цуглуулж, холбогдох тооцооллыг хийдэг.

Сарын давтамжтайгаар: “Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл, борлуулалтын сарын мэдээ”-ний маягтаар аж үйлдвэрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ААНБ-уудын гүйцэтгэлийг биет хэмжээ, үнийн дүнгээр тухайн сарын болон жилийн өссөн дүнг цуглуулдаг. Бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг оны үнээр, бүтээгдэхүүний борлуулалтыг, үүнээс гадаад, дотоодын борлуулалт, нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, зарим гол нэр төрлийн бүтээгдэхүүний тухайн сард борлогдоогүй үлдэгдэл, ажиллагчдын тоо, ажилласан цаг зэрэг үзүүлэлтийг тооцдог

ХОЁР. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР

Дорноговь аймагт 2019 оны байдлаар 1751 аж ахуйн нэгж, байгууллага бүртгэлтэй байгаагийн 1261 буюу 72.0 хувь нь үйл ажиллагаагаа тогтмол явуулж байна.


Үйл ажиллагаа явуулж байгаа нийт ААНБ-ын 64 буюу 5.1 хувь аж үйлдвэрийн салбарын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байна.

ЗУРАГ2.1 ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН ТОО, дэд салбараар



Аж үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулж буй нийт ААНБ-ын 12 буюу 18.8 хувь нь уул уурхай, олборлох үйлдвэрийн салбарт, 49 буюу 76.6 хувь нь боловсруулах үйлдвэрийн салбарт, 3 буюу 4.6 хувь нь цахилгаан хий үйлдвэрлэл, усан хангамжийн салбарт ногдож байна.

ЗУРАГ2.2 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН ТОО, дэд салбар, хувиар



■ Цахилгаан хий, үйлдвэрлэл, усан хангамж ■ Уул уурхай олборлох үйлдвэр ■ Боловсруулах үйлдвэр

ЗУРАГ2.3 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛТ, дэд салбараар, тэрбум төгрөгөөр

Уул, уурхай олборлох үйлдвэрлэл



89.4 тэрбум
төгрөг

Боловсруулах үйлдвэрлэл



100.3 тэрбум
төгрөг


Цахилгаан, дулаан үйлдвэрлэл, усан хангамж



8.4 тэрбум
төгрөг

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2019 оны жилийн эцсийн байдлаар 198.1 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд нийт үйлдвэрлэлтийн 45.1 хувийг уул, уурхай олборлох үйлдвэрийн салбар, 50.6 хувийг боловсруулах үйлдвэрлэлийн салбар, 4.3 хувийг цахилгаан, дулаан эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбар тус тус эзэлж байна.


ЗУРАГ2.4 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, дэд салбар, хувиар



■ Уул, уурхай олборлолт ■ Боловсруулах үйлдвэрлэл ■ Цахилгаан, дулаан эрчим хүч, усан хангамжийн салбар


Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлтийн бүтцийг 2010 онтой харьцуулахад уул, уурхай олборлох үйлдвэрлэлийн салбар 41.1 пунктээр, боловсруулах үйлдвэрлэлийн салбар 38.9 пунктээр тус тус өссөн байна. Харин цахилгаан, дулаан эрчим хүч, усан хангамжийн салбар 2010 онд 84.3 хувийг эзэлж байгаад 2019 онд 4.3 хувийг эзэлдэг болж 80.0 пунктээр буурсан байна.

ЗУРАГ2.5 НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ, тэрбум төгрөгөөр, 2010-2019 он



Нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт өмнөх оны мөн үеэс 32.6 тэрбум төгрөгөөр буюу 14.1 хувиар буурсан байна. Үүнд уул, уурхай олборлох салбарын үйлдвэрлэлт 30.7 хувиар, цахилгаан, эрчим хүч, усан хангамжийн салбар 9.1 хувиар тус тус буурсан нь нөлөөлжээ.


ЗУРАГ2.6 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ, аж ахуй нэгжийн хэлбэрээр, хувиар



Нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг аж ахуйн нэгжийн хэлбэрээр авч үзэхэд 2010 онд улсын үйлдвэрийн газар 85.4 хувийг эзэлж байсан бол 2019 онд 4.3 хувийг эзэлж

81.1 пунктээр буурчээ. Харин компаниудын үйлдвэрлэлт 2010 онд 11.5 хувийг, 2019 онд 95.4 хувийг эзэлж байгаа нь 83.9 пунктээр өсчээ.

ЗУРАГ2.7 АЖ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРЫН 2019 ОНЫ НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛТ, сумаар, сая төгрөг



Аж үйлдвэрлэлийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг сумаар авч үзвэл 86864.5 сая төгрөг буюу 43.8 хувийг Даланжаргалан сум, 79778.2 сая төгрөг буюу 40.3 хувийг Хөвсгөл сум, 15528.2 сая төгрөг буюу 7.8 хувийг Өргөн сум, 9248.8 сая төгрөг буюу 4.7 хувийг Сайншанд сум, 4673.8 сая төгрөг буюу 2.4 хувийг Замын-үүд сум, 1688.5 сая төгрөг буюу 0.9 хувийг Мандах сум, үлдсэн 362.2 сая төгрөг буюу 0.2 хувийг бусад сумд үйлдвэрлэсэн байна. Даланжаргалан, Өргөн, Хөвсгөл сумдын бүтээгдэхүүн үйлдвэрлэлт өндөр хувийг эзэлж байгаа нь тус сумдад уул, уурхай олборлолт болон боловсруулах салбарын үйлдвэрийн газрууд үйл ажиллагаа явуулж байгаатай холбоотой юм.


Статистикийн мэдээлэлд хамрагдсан гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өмнөх оны мөн үетэй харьцуулахад дулаан 68.0 мян.ккал-аар, ус түгээлт 98.7 мян.м3-аар, сувагжуулалт 75.7 мян.м3-аар, хиам 11.3 тонноор, тараг 1.0 мян.литрээр, аарц 0.3 тонноор, талх 18.3 тонноор, нарийн боов 62.4 тонноор, хэрчсэн гурил 8.4 тонноор, 367.5 кг-аар, цэвэр ус 338.4 мян.литрээр, вакуум цонх 698.3 м2-аар, хайрга 17.9 мян.м3-аар, бетон зуурмаг 11454.0 м3-аар, цемент 80.4 мян.тонноор, гөлтгөнө 8917 тонноор, замын хавтан, хашлага 20894.7 м2-аар, дээл 109 ширхгээр, жижиг төмөр эдлэл 5130.0 мянган төгрөгөөр тус тус илүү үйлдвэрлэгджээ.

ХҮСНЭГТ2.1 БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, гол нэр төрлөөр, биет хэмжээгээр


Дэд салбар	Хэмжих нэгж	2016	2017	2018	2019	2019 2018
Цахилган, дулаан эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж						
Цахилгаан эрчим хүч	мян.кв.ц	307.1	123.3	0	0	0
Дулааны эрчим хүч	мян.ккал	110.5	111.6	120.7	188.7	156.3
Түгээсэн цэвэр ус	мян.м3	810.8	784.6	886.6	985.3	111.1
Сувагжуулалт	мян.м3	601.3	577.5	668.7	744.4	111.3
Уул, уурхай олборлох аж үйлдвэр						
Нүүрс	тн	442.9	1455.9	1624.8	1000.7	61.6
Боловсруулах аж үйлдвэр						
Адууны мах	тн	0	10968.7	45	0	0
Хиам	тн	8.3	8.9	9.6	20.9	217.7
Шингэн сүү	мян.л	27	44.1	52.4	50	95.4
Тараг	мян.л	21.6	26.4	30.1	31.1	103.3
Зайрмаг	мян.ш	0.8				
Ааруул	тн	2.5	3.7	2.4	2	83.3
Цөцгий	тн	0.2	2.4	3	2.6	86.7
Аарц	тн	0	4.5	3.6	3.9	108.3
Шар тос	тн	0.7	1	0.8	0.1	12.5
Талх	тн	112.3	142.4	125.8	144.1	114.5
Нарийн боов	тн	62.6	56.8	81.8	144.2	176.3
Бялуу	тн	2.2	3.3	4.5	3.2	71.1
Хэвийн боов	тн	2.5	1	1.4	0.8	59.3
Хэрчсэн гурил	тн	24.8	32.3	17.9	26.3	146.9
Ногоон цай /загсгал цай/	кг	225.9	245	392.5	760	193.6
Цэвэр ус	мян.л	2651.4	2328.9	2017.2	2355.6	116.8
Вакуум цонх	м2	1377.3	1875.6	2196.8	2895.1	131.8
Хайрга	мян.м3	17.4	8.7	23.9	41.8	174.9
Бетон зуурмаг	м3	362.2	3951.5	10969.9	22423.9	2.0 ²
Цемент	мян.тн	83.1	285.7	603.9	684.3	113.3
Блок	мян.ш	49.3	23.9	7.1	4.5	63.4
Гөлтгөнө	тн			7249	16166	2.2 ²
Замын хавтан, хашлага	м2	0	1425	3146.4	24041.1	7.6 ²
Дээл	ш	416	221	374	483	129.1
Бусад жижиг, оёдол	мян.төг	33279.8	17860.2	44477.0	27929.5	62.8
Модон эдлэл	мян.төг	38977.7	51954.6	95122	36289.0	38.1
Эсгий, эсгий эдлэл	мян.төг	6618.5	3590.0	2600.0	0	0.0
Жижиг төмөр эдлэл	мян.төг	745.0	822.0	560.0	5690.0	10.2 ²

Аж үйлдвэрийн салбарын борлуулалт 2019 онд 301.9 тэрбум төгрөгт хүрсэн байна. Нийт борлуулатын 192.8 тэрбум төгрөг буюу 63.9 хувийг уул, уурхай олборлох үйлдвэрлэлийн салбар, 99.2 тэрбум төгрөг буюу 32.9 хувийг боловсруулах үйлдвэрлэлийн салбар, 9.8 тэрбум төгрөг буюу 3.3 хувийг цахилгаан, дулаан эрчим хүч, усан хангамжийн салбар эзэлж байна.

ЗУРАГ2.8 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН 2019 ОНЫ НИЙТ БОРЛУУЛАЛТ, дэд салбараар



ЗУРАГ2.9 НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БОРЛУУЛАЛТ, тэрбум төгрөгөөр, 2010-2019 он



Нийт бүтээгдэхүүн борлуулалт өмнөх оноос 37.3 тэрбум төгрөгөөр буюу 11.0 хувиар буурсан байна.

ХҮСНЭГТ2.3 АЖ ҮЙЛДВЭРИЙН МЭДЭЭНД ХАМРАГДСАН АЖ АХУЙН НЭГЖ, ИРГЭДИЙН ТОО

Салбар	ААН	ИРГЭН
Дүн	42	70
Уул уурхай олборлох аж үйлдвэр	6	
Нүүрс олборлолт	4	
Бусад ашигт малтмал олборлолт	2	
Боловсруулах аж үйлдвэр	33	70
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	16	36
мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	1	
сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	1	
хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	14	36
Хувцас үйлдвэрлэл	1	17
Гутал үйлдвэрлэл		2
Мод, модон эдлэл үйлдвэрлэл	1	5
Машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр	1	
эдлэл үйлдвэрлэл		4
Боловсруулах үйлдвэрийн бусад	14	6
Цахилгаан, дулааны эрчим хүч		
үйлдвэрлэлт, усан хангамж	3	
Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл	3	
Ус ариутгал, усан хангамж		

Аж үйлдвэрийн салбарын мэдээнд нийт 112 нэгж хамрагдсанаас 70 нь өрхийн аж ахуй эрхэлсэн иргэд байна. 2019 оны мэдээнд модон эдлэл үйлдвэрлэлийн чиглэлээр 1 ААНБ, цэвэр ус үйлдвэрлэлтийн чиглэлээр 1 ААНБ, блок үйлдвэрлэлт-2, төмөр эдлэл үйлдвэрлэл-2, хувцас үйлдвэрлэл-4, гутал үйлдвэрлэл-1, хүнс үйлдвэрлэл-6 иргэн тус тус шинээр хамрагджээ.

ХҮСНЭГТ2.4 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН АЖИЛЛАГЧДЫН ТОО

Салбар	2015	2016	2017	2018	2019	2019 2018
Бүгд	841	1142	1436	1685	2008	119.2
Олборлох үйлдвэр	170	269	144	480	551	114.8
Боловсруулах үйлдвэр	309	474	948	822	1080	131.4
Цахилгаан хий үйлдвэрлэл, ус хангамж	362	399	344	383	377	98.4

Аж үйлдвэрийн салбарын статистикийн мэдээнд хамрагдсан байгууллагын ажиллагчдын тоо өмнөх оноос 19.2 хувиар өссөн байна. Салбараар авч үзвэл уул, уурхай олборлох үйлдвэрлэлийн салбарын ажиллагчдын тоо 14.8 хувиар,

боловсруулах салбарын үйлдвэрлэлийн салбарын ажиллагчдын тоо 31.4 хувиар тус тус өсчээ.

ХҮСНЭГТ2.5 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ХӨДӨЛМӨРИЙН БҮТЭЭМЖ, салбар, дэд салбараар, мян төг

Салбар	2016	2017	2018	2019
	тэрбум.төгрөг			
Дүн	29.8	107.4	126.2	98.7
Уул уурхай олборлох аж үйлдвэр	54.5	645.4	222.6	165.0
Нүүрс олборлолт	54.5	645.4	222.6	193.1
Бусад ашигт малтмал олборлолт				
Боловсруулах аж үйлдвэр	23.3	113.7	106.6	92.1
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	11.6	209.2	7.6	11.1
Хувцас үйлдвэрлэл	3.0	4.8	3.4	10.1
Гутал үйлдвэрлэл	5.4	4.7	13.4	11.4
Мод, модон эдлэл үйлдвэрлэл	3.6	5.8	15.9	13.8
Машин тоног төхөөрөмжөөс бусад жижиг төмөр эдлэл үйлдвэрлэл	0.7	0.4	0.4	1.4
Боловсруулах үйлдвэрийн бусад	32.1	86	133.5	104.6
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж	22	22.9	24.3	22.4
Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл	33.4	29.8	32.0	34.1
Ус ариутгал, усан хангамж	8.9	14.6	15.0	9.8

Аж үйлдвэрийн салбарын 2019 оны хөдөлмөрийн бүтээмж нь 2018 оноос 21.8 хувиар буурсан байна.

ГУРАВ. БАРИЛГЫН САЛБАР

БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ



БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН БҮТЭЦ, барилгын төрлөөр



ОРОН СУУЦ



Барилгын салбарт эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал (ISIC 4.0)-ын дагуу барилга угсралт, иргэний зориулалттай инженерийн байгууламжийн угсралтын үйл ажиллагаа, барилгын тусгай үйл ажиллагаа гэсэн 3 дэд салбарын ажиллагааг хамруулан авч үздэг.

Бизнес регистрийн санд 2019 оны эцэст нийт 1751 аж ахуйн нэгж, байгууллага бүртгэлтэй байгаагийн 72 буюу 4.1 хувь нь барилгын салбарт хамаарч байна. Нийт бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагын дүнд барилгын салбарт бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагын эзлэх хувь өмнөх оноос 0.7 пунктээр буурсан байна.

Барилгын салбарт бүртгэлтэй 72 ААНБ-аас 58 буюу 80.5 хувь нь үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулахад 3 ААНБ буюу 5.4 хувиар нэмэгдсэн байна.

ЗУРАГ3.1 БАРИЛГЫН САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ААНБ-ЫН ТОО, жил бүрийн эцэст



Тус салбарт үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын тоо тасралтгүй өссөн нь төрөөс ипотекийн жилийн 8 хувийн хүүтэй зээл, барилгын материалын үнэ, орон сууцны үнэ тогтворжуулах хөтөлбөр гэх мэт хүн амыг орон сууцаар хангах бодлогыг хэрэгжүүлсэнтэй холбоотой байна.

Аймгийн ДНБ-ий хэмжээ 2018 оны гүйцэтгэлээр 368.3 тэрбум төгрөгт хүрсний 6.0 тэрбум төгрөг буюу 1.6 хувийг барилгын салбар бүрдүүлж байна. Барилгын салбарын нэмэгдэл өртгийн хэмжээ 6.0 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 0.2 тэрбум төгрөг буюу 3.4 хувиар нэмэгдсэн байна. Барилгын салбарын нэмэгдэл өртгийн ДНБ-д эзлэх хувь 2018 онд 1.6 хувь байгаа нь өмнөх оноос 0.3 пунктээр буурсан байна.

ЗУРАГ3.2 БАРИЛГЫН САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТӨГ, үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр, сая төгрөгөөр




2019 онд нийт 170117.4 сая төгрөгийн шинэ барилга, өргөтгөл, шинэчлэлт, их засварын ажил хийсэн нь өмнөх онтой харьцуулахад 59.8 хувиар буурсан байна. Барилгын нийт хөрөнгө оруулалтын 15.9 хувийг улсын төсвийн, 3.3 хувийг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар, үлдэх хувийг хөрөнгө оруулалтын бусад эх үүсвэрээр санхүүжүүлжээ.

ХҮСНЭГТ3.1 БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, оны үнээр, сая төгрөг

	2015	2016	2017	2018	2019
Улсын дүн	2290540.3	2482406.9	3130660.7	4009817.5	4747504.2
Төвийн бүс	317761.1	176338.4	662848.4	1417255.0	1738541.2
Дорноговь аймаг	28878.8	17046.2	111924.1	423234.8	170117.4
Улсын дүнд эзлэх хувь	1.3	0.7	3.6	10.6	3.6
Бүсийн дүнд эзлэх хувь	9.2	9.7	16.9	29.9	9.8

Барилга угсралт их засварын ажлын 58.8 хувь нь инженерийн барилга, байгууламж, 26.8 хувь нь орон сууцны бус барилга, 10.7 хувь нь орон сууцны барилга, 3.6 хувь нь их засварын ажил байна. Өмнөх оноос орон сууцны бус барилгынх 10.3 пункт, орон сууцны барилгын эзлэх хувь 5.9 пункт, их засварын ажлынх 2.7 пунктээр тус тус өсч, инженерийн барилга, байгууламжийн эзлэх хувь 18.9 пунктээр буурсан байна.


ЗУРАГ3.3 БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, төрлөөр, мян төг



ХҮСНЭГТ3.2 АШИГЛАЛТАНД ОРУУЛСАН ОРОН СУУЦ, м2, оны эцэст

		Хэмжих нэгж	2016	2017	2018	2019	2019 2018
Нийт талбай		м2	6453.0	18696.5	19666.6	31143.6	158.4
өмчийн хэлбэр	Төрийн	м2		126.0		192.0	
	Хувийн	м2	6453.0	18570.5	19666.6	30951.6	157.4
Сууцны талбай		м2	5616.0	14792.5	15790.4	26098.6	165.3
өмчийн хэлбэр	Төрийн	м2		116.0		160.0	
	Хувийн	м2	5615.0	14676.5	15790.4	25938.6	164.3

ЗУРАГ3.4 АШИГЛАЛТАНД ОРУУЛСАН ОРОН СУУЦАНД АМЬДАРЧ БУЙ өрх, хүн амын тоо



ДӨРӨВ. ЭДИЙН ЗАСАГТ ХУДАЛДААНЫ САЛБАРЫН ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ

1. Худалдааны салбарын эдийн засгийн өсөлт

Бизнес регистрийн санд 2019 оны жилийн эцсийн байдлаар бүртгэлтэй нийт 1261 аж ахуйн нэгж, байгууллага идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаагийн 370 аж ахуйн нэгж буюу 29.3 хувь нь худалдааны салбарын аж ахуйн нэгж, байгууллага байна.

ХҮСНЭГТ4.1 ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО 2016-2019 оноор

	2016	2017	2018	2019
ААНБ-ын тоо-Бүгд	1298	1439	1597	1751
Үйл ажиллагаа явуулж буй ААН байгууллагын тоо	1002	1069	1161	1261
Худалдааны салбарын аж ахуйн нэгжийн тоо	321	338	351	370
Худалдааны салбарын аж ахуйн нэгжийн эзлэх хувь	32.0	31.6	30.2	29.3

Аймгийн хэмжээнд худалдааны салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага 2019 онд 370 болж өмнөх оны мөн үеэс 19 буюу 5.4 хувиар өсч, үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын дүнд эзлэх хувиар авч үзвэл 2019 онд 29.3 хувь болж, 2016 оноос 2.7 пунктээр буурсан байна. Худалдааны салбарын аж ахуйн нэгжийн тоо сүүлийн жилүүдэд тогтмол нэмэгджээ.


ЗУРАГ4.1 ХУДАЛДААНЫ САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ, ажиллагчдын тооны бүлгээр



Дорноговь аймагт үйл ажиллагаа явуулж байгаа худалдааны салбарын аж ахуйн нэгж, байгууллагын 97.3 хувийг 1-9 ажиллагчидтай аж ахуйн нэгж, байгууллага, 10-19

ажиллагчидтай аж ахуйн нэгж, байгууллага 2.2 хувийг, 20-49 ажиллагчидтай аж ахуйн нэгж, байгууллага 0.3 хувийг эзэлж, үлдэх 0.3 хувийг 50-иас дээш ажиллагчидтай аж ахуйн нэгж, байгууллага бүрдүүлж байна.

ЗУРАГ4.2 ХУДАЛДААНЫ САЛБАРТ АЖИЛЛАГЧДЫН ТОО



Худалдааны салбарт ажиллагчдын тоо 2019 онд 370 болж өмнөх оноос 7.8 хувиар, 2016 оноос 34.1 хувиар тус тус өсчээ. Сүүлийн жилүүдэд тасралтгүй нэмэгдэж, жилд дунджаар 31 хүнээр нэмэгдэж байна.

2.Худалдааны нийт борлуулалт аймаг, бүсээр

Худалдааны салбарын нийт борлуулалт гэж тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний борлуулалтын дүн бөгөөд тайлант хугацаанд худалдааны салбарын аж ахуйн нэгжийн цэвэр борлуулалтын нийлбэрийг хэлнэ.

ХҮСНЭГТ4.2 ХУДАЛДААНЫ НИЙТ БОРЛУУЛАЛТ аймаг, бүсээр сая төгрөг 2016-2019 он

Аймаг	2016-IV	2017-IV	2018-IV	2019-IV	2019 2016	2019 2018
Дорноговь	7832.0	32458.3	54227.4	70735.7	9.0²	130.4
Дундговь	5519.0	12907.1	16756.3	23062.2	4.0 ²	137.6
Өмнөговь	37554.8	137729.5	213263.4	190306.7	5.0 ²	89.2
Сэлэнгэ	6701.8	29087.6	44181.6	47372.7	7.0 ²	107.2
Төв	5227.5	34312.3	32938.9	36851.5	7.0 ²	111.9
Дархан-Уул	40734.0	63151.0	88894.6	105702.0	2.5 ²	118.9
Говьсүмбэр	6728.3	19687.4	31589.5	40300.0	5.9 ²	127.6

Бөөний болон жижиглэн худалдааны салбарын нийт борлуулалт 2019 онд 70735.7 сая төгрөгт хүрч, өмнөх оноос 16508.3 сая төгрөг буюу 30.4 хувиар өссөн байна.

ДҮГНЭЛТ

Аж үйлдвэрийн салбарын эдийн засгийн үзүүлэлтүүдэд аж ахуйн нэгж байгууллагын зардал, бүтээгдэхүүний үйлдвэрлэлт биет хэмжээ, үнийн дүнгээр, бүтээгдэхүүний борлуулалт, үндсэн хөрөнгө болон санхүүгийн байдлыг харуулсан үзүүлэлтүүдийг оруулдаг. Тэдгээр үзүүлэлтүүдийг гаргах мэдээллийн эх сурвалж нь үйлдвэрийн газруудын сар, улирал, жилийн тайлан болно.

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлтийн хувьд 2019 онд 198.1 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд өмнөх оны мөн үеэс 32.6 тэрбум төгрөгөөр буюу 14.1 хувиар буурсан байна. Нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн дийлэнх хувийг уул, уурхай олборлох салбарын үйлдвэрлэл эзэлж байна.

Төр засгаас үйлдвэржилтийг дэмжсэн бодлого хөтөлбөрийн амжилттай хэрэгжүүлэн, бүтээгдэхүүний нэр төрөл нэмэгдэж, цаасан уут, гар нүүрийн саван, амны хаалт/маск/ зэрэг бүтээгдэхүүнийг шинээр нэмж үйлдвэрлэжээ.

Аж үйлдвэрийн салбарын борлуулалт 2019 онд 301.9 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд үүний 61.1 хувь буюу 185.4 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүний гадаад зах зээлд борлуулсан байна. Нийт борлуулалтын 192.8 тэрбум төгрөг буюу 63.9 хувийг уул, уурхай олборлох үйлдвэрлэлийн салбар, 99.2 тэрбум төгрөг буюу 32.9 хувийг боловсруулах үйлдвэрлэлийн салбар, 9.8 тэрбум төгрөг буюу 3.3 хувийг цахилгаан, дулаан эрчим хүч, усан хангамжийн салбар эзэлж байна.

Барилгын нийт хөрөнгө оруулалтын 15.9 хувийг улсын төсвийн, 3.3 хувийг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар, үлдэх хувийг хөрөнгө оруулалтын бусад эх үүсвэрээр санхүүжүүлжээ. Барилга угсралт их засварын ажлын 58.8 хувь нь инженерийн барилга, байгууламж, 26.8 хувь нь орон сууцны бус барилга, 10.7 хувь нь орон сууцны барилга, 3.6 хувь нь их засварын ажил байна.

Өмнөх оноос орон сууцны бус барилгынх 10.3 пункт, орон сууцны барилгын эзлэх хувь 5.9 пункт, их засварын ажлынх 2.7 пунктээр тус тус өсч, инженерийн барилга, байгууламжийн эзлэх хувь 18.9 пунктээр буурсан байна.

Манай аймгийн хувьд Худалдааны салбар нь ажиллах хүчний зах зээлд томоохон байр суурь эзэлдэг салбарын нэг бөгөөд сүүлийн жилүүдэд ихээхэн өөрчлөлтүүд бий болж худалдааны үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллага тогтмол өсч өмнөх оноос 19 аж ахуйн нэгж байгууллага нэмэгдсэн байна.

Худалдааны салбарын аж ахуйн нэгжийн эзлэх хувь нь 2019 оны байдлаар нийт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн 29.3 хувийг эзэлж өмнөх оноос 2.7 пунктээр буурсан байна.

Худалдааны салбарын аж ахуйн нэгж, байгууллагын ажилчдын тоо сүүлийн жилүүдэд жилд дунджаар 19 хүнээр нэмэгдэж, 97.3 хувь нь 1-9 ажиллагчидтай жижиг аж ахуйн нэгж, байгууллага байна. Энэ нь аж жижиглэн худалдаа, дэлгүүрийн чиглэлээр илүү үйл ажиллагаа явуулж байгаатай холбоотой юм.

Худалдааны салбарын нийт борлуулалт 2019 онд 58025.9 сая төгрөгт хүрч, өмнөх оноос 65.6 хувиар буурсан байна.

Худалдааны салбарын өнөөгийн байдалд дүгнэлт хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулах, төлөвлөхөд энэхүү танилцуулга, судалгааны материал нь суурь мэдээлэл болох юм.

АШИГЛАСАН НОМ МАТЕРИАЛ:

1. www.1212.mn сайт
2. dornogovi.nso.mn сайт
3. Аймгийн нийгэм эдийн засгийн 2019 оны жилийн эцсийн танилцуулга